

АВЛИГА ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН  
/2024 оны жилийн эцсийн байдлаар/

№	Хөтөлбөр/ төслийн агуулга	Гүйцэтгэл
1.	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар: <b>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2016.11.03, дугаар 51</b>	Төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.
2.	Санхүүжилтийн эх үүсвэр:	Улс, орон нутгийн төсөв, гадаад улс, олон улсын байгууллагын хандив, тусламж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, хөрөнгө, хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр
3.	Хэрэгжих нийт хугацаа: 2 үе шаттай. 2016-2019 он, 2020-2023 он	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: ЗДТГазар Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Төрийн албан хаагчид, иргэд
4.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p><b>Зорилт 1.</b> Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх</p> <p><b>Зорилт 2.</b> Зорилт 2. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх</p> <p><b>Зорилт 3.</b> Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх.</p> <p><b>Зорилт 4.</b> Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх.</p> <p><b>Зорилт 5.</b> Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх.</p> <p><b>Зорилт 6.</b> Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэх</p> <p><b>Зорилт 7.</b> Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх</p>



Зардал	Төсөв /нийт шаардагдах зардал/		хувь
	Төсөв /он/	гүйцэтгэл	
5.	Үүнд: Багц 1	2024 2.100.0	100%
6.	Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ.		
6.1	1-р зорилтын хүрээнд:	<p>1.1. 2024 онд Улс төрийн 2, Төрийн үйлчилгээний удирдах 2 нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг Авилгатай тэмцэх газарт хүргүүлж ирсэн дүгнэлтийг үндэслэн томилгоожуулж нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг ханган олон нийтэд сурталчилан ажилласан.</p> <p>1.2. 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хурлаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль"-ийг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний дүрмийг мөрдүүлэх, ажлын хариуцлагыг дээшлүүлэх ажлын хүрээнд сумын ЗДТГ-ын ёс зүйн дэд зөвлөлөөс тухай онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө 3 зорилт 10 арга хэмжээтэй батлан хэрэгжилтийг ханган үр дүнг тооцон ажиллаж байна. Засаг даргын Тамгын газраас Улаанбаатар хотод нутгийн өөрөө удирдлагын академид 1 хоногийн сургалт авч, нийт 19 албан хаагч оролцсон. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ЕБС "Залуу багш нарт ёс зүйн" сургалт 1, 1 дүгээр цэцэрлэг "Багшийн ёс зүй" сургалт 1, Эрүүл мэндийн төв нь "Эмч, эмнэлгийн ажилтны ёс зүй" сургалт 1, Засаг даргын Тамгын газар "Төрийн албаны харилцааны үр чадвар" сэдэвт сургалт 1, нийт 4 сургалтад нийт 132 гаруй албан хаагч, ажилчид хамрагдсан. Төрийн байгууллагууд ёс зүйн төлөвлөгөө гарган батлуулж, мөрдөн "Ёс зүйн зөрчил гаргахгүй" гарын үсгийн баталгаа, ёс зүйн хувийн хавтас, хариуцлагын талон, иргэдээс гомдол, санал авах хайрцаг зэрэг ажлуудыг зохион байгуулж ажилласан.</p> <p>1.3. Төрийн жинхэнэ албан хаагчдийг томилж, чөлөөлөхөд улс төрийн нөлөөллөөс ангид байлгаж холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажилласан. 2024 онд нийтийн албанд холбогдох хуулийн дагуу 4 томилгоо хийгдсэн.</p> <p>1.4. Төрийн байгууллагууд Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан сумын Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг ханган дүн шинжилгээ хийж ажилласан.</p> <p>1.5. Нийтийн албан тушаалтантай холбоотой авилга ашиг сонирхол, ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, санал ирээгүй.</p> <p>1.6. Төрийн байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх мэдээлэл солилцох нөхцөл боломжийг сайжруулах зорилгоор сар бүр 2-оос дээш удаа байгууллагын дарга, эрхлэгч нарын мэдээлэл солилцох хурлыг хийж хэвшсэн.</p>	



	<p>1.7. Эрх зүйн сургалт сурталчилгаа болон төрийн албан хаагчдын сургалтын төлөвлөгөө гарган батлуулж биелэлтийг нь ханган ажиллаж байна. Төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт сурталчилгааны төлөвлөгөө гаргаж биелэлтийг хангаж ажилласан</p> <p>1.8. Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх шийдвэрлэх журам”-ын 2.5.1 заалтыг дагуу /төрийн захиргааны албан хаагчийн баримтлах ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах/ ЗДТГ-ын албан хаагчид нь төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн дүрмийг сахин олон нийтэд тайлагнаж ажилласан.</p>
<p>2-р зорилтын хүрээнд:</p>	<p>Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжсэнээр E-mongolia цахим үйлчилгээний нэгдсэн системээс 1008 төрлийн лавлагаа тодорхойлолт, бичиг баримтын захиалга, газар, үл хөдлөх хөрөнгө, нийтлэг хэрэглээ, эрүүл мэнд, зөвшөөрөл, тодорхойлолт, дүгнэлт акт, бүртгэл, шилжилт хөдөлгөөн, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, нийслэл, аймаг, яамнаас гарах бичиг баримтуудыг иргэд чирэгдэлгүй түргэн шуурхай авч байна.</p> <p>2.1 Суманд Албан байгууллага, аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд байгууллагын дотоод хяналт болон Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас томилогдсон ажлын хэсэг байнгын хяналт тавин ажиллаж байна.</p> <p>2.2 Хөдөөгийн багийн иргэдээс болон өдөр тутамдаа иргэдээс төрийн үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгааг албан хаагчид тус бүрээр авч анализ дүгнэлт хийж ажилладаг. Албан байгууллагуудын үйл ажиллагаанд жил бүр хөндлөнгийн хяналтыг аудитын байгууллага хийж байна. Мөн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас үнэлэлт дүгнэлт өгөн ажиллаж байна.</p> <p>2.3 Орон нутгийн хэмжээнд хэрэгжиж буй урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд хагас бүтэн жилээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал үнэлэлт дүгнэлт өгөн ажиллаж байна.</p>
<p>3-р зорилтын хүрээнд:</p>	<p>Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ болон 2025 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төлөвлөгөөг 2-р сарын 1-ний дотор ил тод нээлттэй сурталчлах ажлын хүрээнд, боршур гарын авлага, видео танилцуулга, илтгэл бэлтгэж цаас болон цахимаар иргэдэд хүргэсэн. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийг ОНХС-ийн удирдлага мэдээллийн системд оруулах, сумын веб хуудас, шилэн дансны нэгдсэн систем, Бат-Өлзий сумын нэгдсэн фейсбүүк групп, Өв.Бат-Өлзий сумын санхүүгийн алба пэйж хуудас</p>



	<p>байршуулан иргэдэд түгээсэн мөн байгууллагын болон санхүүгийн албаны мэдээллийн самбарт байршуулан ажиллаж байна.</p> <p>Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилгыг худалдан авах ажиллагааны <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим хуудсанд тогтмол байршуулж, тендерийн явц, гүйцэтгэл, үр дүнг тухай бүр 100 хувь ил тод нээлттэй мэдээлсэн.</p> <p>3.1 Орон нутгийн 2024 оны төсвийн төслийг боловсруулан ИТХ-аар хэлэлцүүлж ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 18/03 тоот тогтоолоор батлуулсан, 2024 оны тодотголын төсвийг боловсруулан, ИТХ-аар хэлэлцүүлэн 2024.09.25-ны өдрийн 22/01 дүгээр тогтоолоор батлуулсан, төсөв батлах хуралд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төслийн ил тод байдлыг хангах зорилгоор 8-10 иргэдийг оролцуулсан. 2024 оны төсвийн гүйцэтгэлийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Батлагдсан төсвийн мэдээллээр 2024 оны төсвийн фосторыг хэвлэн иргэдэд түгээсэн, "Иргэдийн төсөв" гарын авлагыг иргэдэд танилцуулж, цахим ном, төсвийн тогтоолыг сумын веб хуудас, шилэн дансны нэгдсэн систем, улсын хэмжээний ОНХС-ийн пэйж хуудас, Бат-Өлзий сумын нэгдсэн фейсбүүк групп, Өв.Бат-Өлзий сумын санхүүгийн алба пэйж хуудас байршуулан иргэдэд түгээсэн мөн байгууллагын болон санхүүгийн албаны мэдээллийн.</p>
<p>4-р зорилтын хүрээнд:</p>	<p>Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтад 18 төрийн албан хаагчийг хамруулсан, иргэн, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг тус мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтад хамруулаагүй. Цахим тендерийн үнэлгээний хороонд ажиллаж байгаа үнэлгээний хорооны гишүүдэд ашиг сонирхлын мэдүүлгийг журмын дагуу бөглүүлж ажиллаж байна.</p> <p>Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим хаягт байршуулан ажиллалаа. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> цахим хуудсандаа тогтмол байршуулсан.</p> <p><a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим хаягт тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг байршуулан цахим хэлбэрээр тендерийг зохион байгуулан ажиллаж байна.</p>
<p>5-р зорилтын хүрээнд:</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа хууль тогтоомжийн дагуу тендерийг нээлттэй хэлбэрээр шударга өрсөлдөөнийг дэмжих замаар цахимаар зарлан биелэлтийг нь хангаж байна.</p>



	6-р зорилтын хүрээнд:	Төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгож нийтэд <a href="http://www.shilepans.gov.mn">www.shilepans.gov.mn</a> цахим хаягаар болон мэдээллийн самбарт байршуулан ажиллаж байна. Төрийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг Сумын ИТХ, Аудитын байгууллага тавин ажиллаж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах үнэлгээний хорооны гишүүнд иргэдийн төлөөллийг тогтмол оруулан хөндлөнгийн хяналтыг бий болгон ажиллаж байна.							
	7-р зорилтын хүрээнд:	АТҮХ-ийн заалтыг сумын Авлигын эсрэг үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг нь ханган ажилласнаар тухайн албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчил гаргалгүй ажилласан. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тухай бүр баяжуулалт хийж, холбогдох газарт цаг хугацаанд нь тайланг хүргүүлж ажилласан. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах олон нийтэд сурталчилах зорилгоор төрийн албан хаагчид болон төр, хувийн хэвшлийн байгууллагуудад зөвлөгөө мэдээллийг тогтмол өгч багийн иргэдийн нийтийн хурлуудад хууль тогтоомжийн талаар мэдээлэл өгч гарын авлага бэлтгэн тарааж мэдээллийн самбар болон цахимаар олон нийтэд түгээн ажилласан.							
7.	Дүгнэлт /ололт, дутагдал, анхаарах асуудлууд/								
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ								
9.	Төсөл, хөтөлбөрийн дундаж үнэлгээ, дүгнэлт /өөрийн үнэлгээ/	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 5	Зорилт 6	Зорилт 7
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ	7	90%	90%	100%	100%	100%	100%	90%



БИЕЛЭЛТ ГАРГАСАН: ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Н.БАТ-ЭРДЭНЭ